



МОНГОЛЫН
ХӨРӨНГИЙН
БИРЖ

Э-сонин

90-р дугаар

01-Р САР

2021






ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ


/2021.01.31-ний өдрийн байдлаар/

1. Арилжаа явагдсан өдөр	20
2. Нийт арилжааны үнийн дүн /төгрөг/	14,909,253,953.57
Хувьцаа /хоёрдогч/	10,641,587,524.26
Багцын арилжаа	3,761,639,000
Хөрөнгө оруулалтын сан /хоёрдогч/	108,079,149
ХБҮЦ /анхдагч/	4,000,000,000.00
ХБҮЦ /хоёрдогч/	120,603,000.00
Компанийн бонд /хоёрдогч/	38,984,280
3. Нийт арилжигдсан үнэт цаасны тоо ширхэг	61,738,157
Хувьцаа /хоёрдогч/	60,734,042
Багцын арилжаа	35,034,060
Хөрөнгө оруулалтын сан /хоёрдогч/	993,429
ХБҮЦ /анхдагч/	10,000
ХБҮЦ /хоёрдогч/	299
Компанийн бонд /хоёрдогч/	387
4. Нийт хийгдсэн хэлцлийн тоо	12,608


TOP-20 ИНДЕКС




ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ



MSE A ИНДЕКС



MSE B ИНДЕКС



БҮРТГЭЛТЭЙ ҮНЭТ ЦААС

1. Нийт үнэт цаас	195
100% төрийн өмчит	17
Төрийн өмчийн оролцоотой	10
Хувийн өмчийн	165
I ангилал	18
II ангилал	42
III ангилал	134
Компанийн бонд	1
Хөрөнгө оруулалтын сан	1
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас	1

Гишүүн үнэт цаасны компани

1. Гишүүн Үнэт цаасны компанийн тоо	54
Үүнээс: Брокер, Дилер	54
Андеррайтер	19
Хөрөнгө оруулалтын зөвлөх	14



АРИЛЖААНД ИДЭВХТЭЙ ОРОЛЦСОН ГИШҮҮН ҮНЭТ ЦААСНЫ КОМПАНИУД

/2021.01.31-ний байдлаар/

	Нэр	Үнэт цаас авсан		Үнэт цаас зарсан		Арилжааны дүн / авсан, зарсан/ (төг)
		Тоо ширхэг	Үнийн дүн (төг)	Тоо ширхэг	Үнийн дүн (төг)	
1	БИДИСЕК ХК	22,738,973	3,972,654,639	25,440,027	4,788,522,191	8,761,176,830
2	АРД СЕКЮРИТИЗ ХХК	12,241,023	4,416,898,455	2,350,026	2,887,798,175	7,304,696,631
3	ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК	14,029	1,832,808,869	96,000	4,056,076,787	5,888,885,656
4	ГОЛОМТ КАПИТАЛ ХХК	1,541,703	1,020,517,023	3,540,857	647,605,542	1,668,122,565
5	АРД КАПИТАЛ ГРУПП ХХК	2,038,668	877,850,935	6,699,382	564,493,709	1,442,344,645
6	ТИ ДИ БИ КАПИТАЛ ХХК	2,531,662	713,532,583	1,052,616	190,519,302	904,051,886
7	БУМБАТ-АЛТАЙ ХХК	1,963,688	325,185,581	7,004,064	563,723,522	888,909,103
8	МИРЭ ЭССЕТ СЕКЮРИТИС МОНГОЛ ХХК	10,258,844	441,461,830	10,174,981	342,033,029	783,494,859
9	СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ХХК	705,046	253,713,834	1,178,327	250,507,299	504,221,134
10	ЭМ АЙ БИ ЖИ ХХК	882	352,800,000	0	0	352,800,000
11	ГҮҮДСЕК ХХК	6,188,125	295,648,606	193,106	17,117,057	312,765,663
12	АПЕКС КАПИТАЛ ҮЦК	517,819	79,698,626	1,059,447	217,716,479	297,415,105
13	НОВЕЛ ИНВЕСТМЕНТ ХХК	79,741	80,508,946	839,596	47,859,840	128,368,785
14	ГАУЛИ ХХК	149,522	101,246,915	96,458	25,797,307	127,044,222
15	БЛЭКСТОУН ИНТЕРНЭЙШНЛ ХХК	0	0	326,676	79,333,335	79,333,335
16	МОНСЕК ХХК	198,147	23,655,606	231,510	49,098,312	72,753,918
17	ТУЛГАТ ЧАНДМАНЬ БАЯН ХХК	785	533,324	448,211	48,275,760	48,809,084
18	БЛҮМСБЮРИ СЕКЮРИТИЕС ХХК	6,148	21,237,870	116,375	23,025,736	44,263,606
19	ГРАНДДЕВЕЛОПМЕНТ ХХК	81,864	10,786,132	109,494	15,297,133	26,083,265
20	ГАЦУУРТ ТРЕЙД ХХК	380,000	20,140,000	21,283	2,056,211	22,196,211

ИДЭВХТЭЙ АРИЛЖИГДСАН ХУВЬЦАА

/2021.01.31-ний байдлаар/

№	Симбол	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн (төг)	Дээд Ханш	Доод Ханш	Өөрчлөлт /%/
1	AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	1,185,366	3,224,205,999	3,500.00	1,600.00	70.65
2	BODI	БОДЬ ДААТГАЛ	20,278,725	2,481,113,623	129.99	120.00	-5.38
3	ERDN	ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ	873,439	868,603,870	1,027.00	851.00	13.40
4	ADB	АРД КРЕДИТ ББСБ	9,577,468	767,619,029	85.00	76.00	1.72
5	SHG	ШАРЫН ГОЛ	1,022,563	739,001,676	899.00	722.51	0.09
6	LEND	ЛЭНДМН ББСБ	12,438,749	379,819,623	33.19	30.60	3.69
7	GOV	ГОВЬ	1,679,808	371,766,465	230.00	192.00	14.29
8	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	7,263,317	324,509,852	49.50	47.64	0.96
9	APU	АПУ	468,782	283,573,554	624.90	585.50	3.05
10	BDS	БИ ДИ СЕК	310,666	264,101,180	950.00	840.01	-8.96
11	TUM	ТҮМЭН ШУВУУТ	1,019,416	173,682,787	179.99	160.00	6.47
12	AIC	АРД ДААТГАЛ	162,668	126,743,171	878.00	705.00	6.13
13	MFC	МОНОС ХҮНС	1,627,380	110,784,939	69.99	65.00	0.78
14	XOC	ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН	993,429	108,079,149	112.00	106.50	1.26
15	UID	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	53,626	78,519,983	1,640.00	1,210.00	26.18
16	INV	ИНВЕСКОР ББСБ	26,061	74,062,297	2,960.00	2,700.00	-1.38
17	TTL	ТАВАН ТОЛГОЙ	10,591	73,630,440	7,120.00	6,650.00	-0.14
18	BUN	БУЛГАН УНДРАГА	19,784	43,430,131	4,669.00	874.92	513.70
19	ONH	ӨНДӨРХААН	35,800	36,695,000	1,025.00	1,025.00	0.00
20	MNP	МОНГОЛ ШУУДАН ХК	47,955	33,369,113	750.00	600.00	-1.47



ХАНШИЙН ӨСӨЛТТЭЙ ХУВЬЦАА

/2021.01.31-ний байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан / Ширхэг/	Хаалтын ханш (төг)		Ханшийн өөрчлөлт (төг)	Өөрчлөлт %/
			2020-12-31	2021-01-31		
1	БУЛГАН УНДРАГА	19,784	760.80	4,669.00	3,908.20	513.70
2	МОНГОЛ АЛТ	242	8,360.00	17,150.00	8,790.00	105.14
3	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	1,185,366	1,758.00	3,000.00	1,242.00	70.65
4	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	53,626	1,230.00	1,552.00	322.00	26.18
5	НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ	129,458	90.01	104.43	14.42	16.02
6	АРВИЖИХ	7	520.00	598.00	78.00	15.00
7	ТЕХНИК ИМПОРТ	3	8,740.00	10,050.00	1,310.00	14.99
8	ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ	5	2,830.00	3,254.00	424.00	14.98
9	ЖУУЛЧИН ГОВЬ	1	10,400.00	11,950.00	1,550.00	14.90
10	МОНГОЛ ШЕВРО	173	1,126.00	1,290.00	164.00	14.56
11	БАГАНУУР	3,792	1,005.00	1,151.00	146.00	14.53
12	ДАРХАН ЗОЧИД БУУДАЛ	100	125.00	143.00	18.00	14.40
13	МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	859	347.54	397.21	49.67	14.29
14	ГОВЬ	1,679,808	192.50	220.00	27.50	14.29
15	ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ	873,439	858.00	972.99	114.99	13.40
16	МОНГОЛ САВХИ	831	450.00	510.00	60.00	13.33
17	ТҮМЭН ШУВУУТ	1,019,416	168.98	179.92	10.94	6.47
18	УБ-БҮК	6,634	400.00	424.58	24.58	6.15
19	АРД ДААТГАЛ	162,668	799.96	848.97	49.01	6.13
20	МОНГОЛ ШИЛТГЭЭН	6	210.08	220.00	9.92	4.72

ХАНШИЙН БУУРАЛТТАЙ ХУВЬЦАА

/2021.01.31-ний байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан / Ширхэг/	Хаалтын ханш (төг)		Ханшийн өөрчлөлт (төг)	Өөрчлөлт %
			2020-12-31	2021-01-31		
1	ОЛЛОО	40,662	34.80	21.02	-13.78	-39.60
2	ГЛОБАЛ МОНГОЛИА	7	2,000.00	1,450.00	-550.00	-27.50
3	МИК ХОЛДИНГ	299	14,950.00	11,510.00	-3,440.00	-23.01
4	Э-ТРАНС ЛОЖИСТИКС	1,199	140.00	110.00	-30.00	-21.43
5	ХАРХОРИН	52	1,740.00	1,480.00	-260.00	-14.94
6	АДУУН ЧУЛУУН	5,435	999.76	860.00	-139.76	-13.98
7	БАЯНТЭЭГ	5	25,500.00	22,080.00	-3,420.00	-13.41
8	ХЭРЛЭН ХИВС	560	48.00	42.00	-6.00	-12.50
9	МЕРЕКС	3,461	28.48	25.00	-3.48	-12.22
10	НЭХЭЭСГҮЙ ЭДЛЭЛ	96	1,750.00	1,550.00	-200.00	-11.43
11	РЕМИКОН	126,837	23.40	21.00	-2.40	-10.26
12	АРИГ ГАЛ	54	2,900.00	2,634.00	-266.00	-9.17
13	БИ ДИ СЕК	310,666	988.00	899.50	-88.50	-8.96
14	АТАР-ӨРГӨӨ	13	60,000.00	55,000.00	-5,000.00	-8.33
15	ТАНДЭМ ИНВЕСТ ББСБ	70,887	20.14	18.50	-1.64	-8.14



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИД АЙЛЧИЛЖ, АРИЛЖААГ НЭЭХ ХҮНДЭТГЭЛИЙН ЦАНГ ЦОХИЛОО



Монгол Улсад хөрөнгийн зах зээл үүсч, Монголын хөрөнгийн бирж байгуулагдсаны 30 жилийн ойг тохиолдуулан арилжааны цан цохих хүндэтгэлийн арга хэмжээ 2021 оны 1-р сарын 18-ний өдөр боллоо. Энэхүү ёслолын арга хэмжээнд Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, УИХ-ын гишүүн, Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны Ерөнхийлөгч Д.Цогтбаатар, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Монголын хөрөнгийн биржийн гүйцэтгэх захирал Х.Алтай нар оролцлоо.



Нээлтийн арга хэмжээний үеэр Ерөнхий сайд У.Хүрэлсүх "30 жилийн туршид хөрөнгийн бирж, хөрөнгийн зах зээл тасралтгүй хөгжин дэвшиж, олон шинэ бүтээгдэхүүнтэй, тогтмол үйл ажиллагаатай, идэвхтэй арилжаатай, хууль эрх зүйн орчны хувьд боловсронгуй болсны зэрэгцээ хөрөнгийн биржийн үйл ажиллагаа, дэд бүтэц, технологийн хувьд олон улсын жишигт хүрч чадсан байна. Сүүлийн жилүүдэд хөрөнгийн зах зээл улам идэвхжиж, хөрөнгө оруулагчид арилжаанд цахимаар оролцох боломж бүрдсэнээс гадна гадаадын хөрөнгийн биржид бүртгэлтэй үнэт цаасыг Монголдоо давхар арилжих, компаниуд үнэт цаас гаргах буухиа үргэлжилсээр байгааг тэмдэглэн хэлэхэд сайхан байна.

Дэлхий дахинаараа КОВИД19 халдварт цар тахлын сорилт бэрхшээлийг даван туулж байгаа хэдий ч эдийн засгаа сэргээх, урт хугацаанд олон тулгуурт дэд бүтцийг бий болгож, тогтвортой, хүртээмжтэй эдийн засгийн өсөлтийг хангахад хөрөнгийн зах зээлийн үүрэг чухал

ҮЙЛ ЯВДАЛ

бөгөөд гарцаагүй болж байна. Тухайлбал, "Эрдэнэс таван толгой" ХК-ийн 1072 хувьцааг дотоодын хөрөнгийн бирж дээр арилжаалж эхлэх, стратегийн ач холбогдол бүхий томоохон ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах, төрийн өмчийн хувьчлалыг хөрөнгийн зах зээлээр дамжуулан хэрэгжүүлж, төрийн өмчит компаниудын засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх шаардлагатай. Тэтгэврийн тогтолцоог шинэчилж, иргэдийн тэтгэврийн хуримтлалыг хөрөнгийн зах зээлээр дамжуулан үр ашигтай удирдах нөхцөлийг бүрдүүлэх зэрэг ажлууд та бүхнийг хүлээж байна. Хөрөнгийн зах зээлийг санхүүгийн зах зээлийн тулгуур, эдийн засгийн хөдөлгөгч хүч болгоход төрийн зүгээс бодлогын болон бусад шаардлагатай дэмжлэгийг цаашид ч тасралтгүй үзүүлсээр байх болно. Ингэснээр иргэдийн амьжиргаа дээшлэх, бизнес эрхлэгчид хямд урт хугацааны хөрөнгө, санхүүгийн эх үүсвэр дотоодоос татан төвлөрүүлэх боломж бүрдэнэ. Түүнчлэн, төрийн өмч хувьчлалын бодлогыг хөрөнгийн зах зээлээр дамжуулан ил тод нээлттэй явуулж, баялгийн шуурхай, тэгш хуваарилалтын зарчмыг хэрэгжүүлэн ажиллах ёстой юм." гэдгийг онцлон тэмдэглэв.

Сангийн сайд Ч.Хүрэлбаатар "Үнэт цаасны зах зээл хурдацтай хөгжиж байна. Эрх зүйн орчин нь боловсронгуй болж, үнэт цаас гаргаж хөрөнгө оруулалт татах үйл ажиллагаа нэмэгдэхийн хэрээр эдийн засаг дахь үүрэг, оролцоо нь улам сайжирч байна. Цаашид технологийн ололт амжилтыг эрчимтэй нэвтрүүлж, хөрөнгийн зах зээлийг хөгжлийг түргэсгэх нь зүйтэй" гэж онцолсон бол УИХ-ын гишүүн, МҮЦАЭХ-ны Ерөнхийлөгч Д.Цогтбаатар Монгол Улсын цаашдын хөгжилд хөрөнгийн зах зээл чухал үүрэгтэй бөгөөд хөрөнгийн зах зээлийн хөгжилд төрийн бодлого дэмжлэг шаардлагатайг тэмдэглэв.



Мөн арга хэмжээний үеэр Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан "Санхүүгийн зохицуулах хороо Сангийн яам, мэргэжлийн холбоо, дэд бүтцийн байгууллагуудтайгаа хамтран үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх чиглэлд олон ажил хийж гүйцэтгэсэн. Хэдийгээр хууль эрх зүйн орчин нь бүрдсэн ч өнөөдрийг хүртэл зах зээлд гараагүй байсан хамтын хөрөнгө оруулалтын сан, нээлттэй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас зэрэг олон шинэ бүтээгдэхүүн гарсан" гэж дурдав.



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ БАЙГУУЛАГДАЖ, ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ ҮҮСЧ ХӨГЖСӨНИЙ 30 ЖИЛИЙН ОЙН МЭНДЧИЛГЭЭ



Монголын хөрөнгийн бирж үүсгэн байгуулагдсаны түүхэн 30 жилийн түүхэн ойн мэндийг биржийн хамт олондоо болон хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхэд хамтран зүтгэж буй зах зээлийн бүх оролцогчиддоо хүргэе.

Монгол Улс тэртээ 30 жилийн өмнө төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас чөлөөт зах зээлийн эдийн засагт шилжих түүхэн үед өмч хувьчлалыг эхлүүлэх зорилгоор Монголын хөрөнгийн биржийг Монгол Улсын Засгийн газрын 1991 оны 22 дугаар тогтоолоор байгуулсан билээ.

Тухайн цаг үед Монгол Улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас чөлөөт зах зээлийн эдийн засагт шилжиж, ард иргэдийг хувийн өмч хөрөнгөтэй болгох, түүнийг нь эдийн засгийн эргэлтэнд оруулах түүхэн чухал ажлыг Монголын хөрөнгийн биржээр дамжуулж хийсэн. Үүний хүрээнд улсын 475 үйлдвэрийн газрууд хувийн өмчид шилжиж, нийт хүн амын тал гаруй хувь нь тэдгээрийн хувьцаа эзэмшигч болж байсан.

Үүнээс хойш 30 жилийн хугацаанд хөрөнгийн зах зээлийн техник технологи, хууль эрх зүйн орчин олон улсын жишгийн дагуу шинэчлэгдэж, манай зах зээл хөгжлийн шинэ шатанд гарлаа.

Сүүлийн жилүүдэд манай хөрөнгийн зах зээлд хувьцаа бондын арилжаа идэвхжиж, шинээр болон нэмж үнэт цаас гаргах зэрэг олон үйл ажиллагаа амжилттай явагдаж байгаагийн зэрэгцээ онцлог шинэ үйл явдлуудаар дүүрэн байлаа. Тухайлбал, 2017-2020 онуудад МХБ дээр түүхэн дээд хэмжээний хувьцаа, ЗГҮЦ-ны арилжаа хийгдсэн, хамгийн олон IPO бүртгэгдсэн, үүнд үнэт цаасны анхны давхар бүртгэл, даатгалын компанийн үнэт цаас бүртгэгдсэн, давхар бүртгэлтэй үнэт цаас гадаадын бирж болон МХБ хооронд хөрвөн арилжигдах боломжтой болсон, манай бирж дээр урьд өмнө арилжигдаж байгаагүй цоо шинэ бүтээгдэхүүнүүд болох хамтын хөрөнгө оруулалтын сан, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас нэвтэрсэн зэрэг ололт амжилттай байна.

Манай улсын эдийн засаг, санхүүгийн зах зээл дэлхийн бусад улс орнуудын зах зээлтэй улам бүр холбогдож, түүний хэрээр гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын

ҮЙЛ ЯВДАЛ

хөрөнгө оруулах сонирхол ч ихээр нэмэгдэж байгаа нь манай улсад үнэт цаас, хөрөнгийн зах зээлийн зохицуулалтыг улам бүр боловсронгуй болгох түүнд оролцогч байгууллагуудын үйл ажиллагааны уялдааг сайжруулах, эрх зүйн орчныг цаашид төгөлдөржүүлэх зайлшгүй шаардлага бидний өмнө тавигдаж байна.

Энэхүү үйл ажиллагаанд Монголын хөрөнгийн бирж идэвхи санаачлагатай оролцож, арилжигдаж буй бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулан зах зээлийн дэд бүтцийг хөгжүүлэхэд хөрөнгийн зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагууд, үнэт цаас гаргагч Та бүхэнтэй бүхий л талаар хамтран ажиллаж байгаад талархаж байна.

Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх Та бидний хамтын ажиллагаа улам бүр дэвжин дээшилж, улс орныхоо эдийн засгийн хөгжилд бодит үр дүнгээ өгч, хөгжлийн түүхээ болон өргөжин хөгжинө гэдэгт эргэлзэхгүй байна.

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТҮҮХЭН



Монгол Улсад хөрөнгийн зах зээл үүсч, Монголын хөрөнгийн бирж байгуулагдсаны 30 жилийн ойг тохиолдуулан арилжааны цан цохих хүндэтгэлийн арга хэмжээний үеэр биржийн үйл ажиллагаатай холбоотой түүхэн үзмэрүүдээр бүрдүүлсэн үзвэрийн танхимыг Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар нар нээж, танхимыг нээсэн тус Сайд нар болон нээлтийн ёслолд оролцсон УИХ-ын гишүүн, Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны Ерөнхийлөгч Д.Цогтбаатар, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан нар анхны зочид болов.

Уг музейд хөрөнгийн биржийг үүсгэн байгуулах анхны тогтоол, түүхэн баримт бичгүүдээс эхлээд тухайн үед хэрэглэж байсан компьютер техник хэрэгсэл, бусад хувцас хэрэгсэл, дурсгалын зүйлүүдийг байрлуулаад байна.



МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧӨӨС МЭНДЧИЛГЭЭ ИРҮҮЛЖЭЭ

Монгол Улсад хөрөнгийн зах зээл үүсч, Монголын хөрөнгийн бирж байгуулагдсаны 30 жилийн ойн баяр 2021 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр тохиож байгаа билээ. Энэ түүхэн үйл явдалд Монгол банкны ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн мэндчилгээ дэвшүүлжээ. Тэрээр мэндчилгээндээ: "Зах зээлийн эдийн засгийн гол тулгуур хөрөнгийн зах зээлийн институци Хөрөнгийн биржийн 30 жилийн хөгжлийг бүтээлцсэн үе үеийн ахмад ажилтан, нийт хамт олон бүхэнд ойн баярын мэндийг хүргэе. Төлөвлөгөөт эдийн засгийн үйлдвэрийн газруудыг хувьцаат компани болгох, тэдгээрийн хувьцааг хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр арилжаалах ажлын хүрээнд 1995 онд анх удаагаа үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа хийгдэж эхэлснээс хойш хөрөнгийн зах зээлийн эрх зүйн орчныг бүрдүүлэн, дотоод болон гадаадын биржийн хооронд үнэт цаас хөрвөх нөхцлийг бий болгож, биржийн бус зах зээлийн эрх зүйн суурь орчныг бүрдүүлж, орон сууцны зээлийн болон түрээсийн багцаар баталгаажсан үнэт цаасыг хаалттай хүрээнд гаргаж, олон нийтэд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг эхлүүлж, зах зээлийн үнэлгээ 3 их наяд төгрөгт хүрсэн амжилтаар гурван арван жилийн ойгоо угтаж буй хөрөнгийн зах зээлийн шийдвэр гаргагч Та бүхэнд талархал илэрхийлье.

Хөрөнгийн бирж үнэт цаасны харилцааг хөгжүүлэх, олон улсын зах зээлд гарч буй шинэ төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээг дотоодын зах зээлд нэвтрүүлэх, үнэт цаасны шинэ арилжааг дэлгэрүүлэх зэрэгт манлайлан ажиллаж байгаагаа бататгана гэдэгт итгэл төгс байна.

Хорин нэгдүгээр зууны хөгжлийг түүчээлэгч жарны хагасын хөрөнгийн зах зээлийн түүхийг тодорхойлогч Хөрөнгийн биржийн бүтээлч хамт олонд улсын эдийн засгийн хөгжилд чухал хөдөлгөөр, иргэд, харилцагчдын байнгын итгэлтэй түнш байхын тэгш ерөөлийг дэвшүүлбэ" гэжээ.

АНХНЫ НЭЭЛТТЭЙ ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСНЫ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН ЗАХИАЛГЫГ НЭЭХ ЁСЛОЛ БОЛОО



Монголын хөрөнгийн биржийн 2021 оны хамгийн эхний бүтээгдэхүүн, анхны нээлттэй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг эхлүүлсэнтэй холбогдуулан цан цохих ёслолын үйл ажиллагаа 2021 оны 1-р сарын 13-ны өдөр боллоо.

ҮЙЛ ЯВДАЛ

Энэхүү арга хэмжээнд Санхүүгийн Зохицуулах Хорооны дарга Д.Баярсайхан, "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Х.Алтай, "Инвекор ББСБ" ХК-ийн дэд захирал Д.Амгаланбаатар болон "Инвекор Капитал ҮЦК" ХХК-ийн Гүйцэтгэх захирал Г.Уянгахишиг нар оролцож, Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны 6388 дахь арилжааг эхлүүлэх хүндэтгэлийн цанг цохилоо. "Инвекор Актив ТЗК" ХХК (MSE:IABS) нь жилийн 14.4%-ийн хүүтэй, 24 сарын хугацаатай, улирал тутамд хүү төлөх нийт 10,000 ширхэг үнэт цаасыг тус бүрийг нь 400,000 төгрөгөөр олон нийт болон стратегийн хөрөнгө оруулагч нарт санал болгон худалдаж, нийт 4.0 тэрбум төгрөг татан төвлөрүүлэх юм.

"ИНВЕКОР АКТИВ" ХБҮЦ-НЫ ОЛОН НИЙТИЙН ЗАХИАЛГА НИЙЛҮҮЛЭЛТЭЭСЭЭ 3.3 ДАХИН ДАВЖ ХААГДЛАА



Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн анхны нээлттэй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас болох "Инвекор актив ХБҮЦ"-ны анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг 2021 оны 01 дүгээр сарын 13-ны өдрөөс 01 дүгээр сарын 14-ний өдрүүдэд авч, захиалга хүлээн авах үйл ажиллагааг амжилттай зохион байгуулж явууллаа.

Арилжааны системд А транчийн стратегийн 4 хөрөнгө оруулагчаас 1,700,000,000 төгрөгийн үнийн дүн бүхий 4 захиалга, олон нийт буюу 89 хөрөнгө оруулагчаас 5,686,800,000 төгрөгийн үнийн дүн бүхий 90 захиалга, Б транчийн 3 хөрөнгө оруулагчаас 600,000,000 төгрөгийн үнийн дүн бүхий 3 захиалга, нийт 7,986,800,000 төгрөгийн үнийн дүн бүхий 19,967 ширхэг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг худалдан авах захиалга бүртгэгдсэн бөгөөд үнэт цаас гаргагчаас ирүүлсэн хуваарилалтын төлөвлөгөөний дагуу 10 сая төгрөг хүртэлх үнийн дүн бүхий захиалгуудыг 100 хувь биелүүлж, үлдсэн дүнг 22.4 хувиар хувь тэнцүүлэн нийлүүлэв. Тус үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаанд олон нийтээс ирүүлсэн захиалга нь татан төвлөрүүлэх дүнгээс 3.3 дахин давсан үзүүлэлт боллоо.



"ИНВЕСКОР АКТИВ" ХБҮЦ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛД АРИЛЖИГДАЖ ЭХЭЛЛЭЭ

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-д бүртгэгдсэн анхны нээлттэй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас болох "Инвескор актив" ХБҮЦ **IABS** үсгэн кодтойгоор 2021 оны 1-р сарын 20-ны өдрөөс эхлэж хоёрдогч зах зээлд арилжигдаж эхэллээ.

ДАВХАР БҮРТГЭЛТЭЙ ҮНЭТ ЦААСНЫ БИРЖ ХООРОНДЫН ХӨРВҮҮЛЭЛТ АМЖИЛТТАЙ ХИЙГДЛЭЭ

"Үнэт цаасны зах зээлийн тухай хууль"-ийн шинэчилсэн найруулга 2013 онд батлагдсанаар үнэт цаасны давхар бүртгэлийг нэвтрүүлэх хууль, эрх зүйн орчин бүрдэж, улмаар үнэт цаасны давхар бүртгэлийн ажиллагааг зохицуулах "Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд Монгол Улсад үнэт цаас гаргах, Монгол Улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд гадаад улсад гаргах үнэт цаасыг бүртгэх журам"-ыг СЗХ болон МХБ-ийн хамтарсан ажлын хэсгээс боловсруулж, СЗХ-ны 2017 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 223 тоот тогтоолоор баталсан.

Тус журамд 2020 оны 8 дугаар сарын 12-ны өдөр оруулсан өөрчлөлтийн дагуу МХБ нь "Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн" /ERDN/-ийн нийт хувьцааг бүртгэж, тус компанийн хувьцаа МХБ болон Торонтогийн хөрөнгийн бирж хооронд хөрвөн арилжаалагдах боломж бүрдсэн билээ.

"Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн"-ийн хувьцаа хөрвүүлэх анхны хүсэлтийг "БиДиСЕК ҮЦК" ХК-аас 2021 оны 1-р сарын 15-нд гаргаж, улмаар Монголын Хөрөнгийн Биржээс Торонтогийн Хөрөнгийн Бирж рүү хувьцааны хөрвүүлэг амжилттай хийгдсэн байна.

Хувьцааг хил дамнуулан хөрвүүлэх нь хөрөнгө оруулагчид аль өндөр ханштай зах зээлийг сонгон хувьцааг арилжих, улмаар ханшийн тэнцвэртэй байдал хангагдах, дотоодын зах зээлд нийлүүлэлт нэмэгдэх, хөрвөх чадварыг сайжруулах зэрэг олон талын ач холбогдолтой юм.

МХБ ХАНШИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ЦАХИМЖУУЛЛАА

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК нь өв залгамжлах гэрчилгээгээр үнэт цаас шилжүүлэх хүсэлт гаргасан иргэдэд үнэт цаасны ханшийн лавлагааг гаргаж өгөх үйлчилгээг 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс "Гэрэгэ системс" ХХК-ийн Гэрэгэ киоскоор дамжуулан олгож эхэллээ.

ҮЙЛ ЯВДАЛ

Гэрэгэ киоск нь татвар, тээвэр, шүүх, харилцаа холбоо, эрүүл мэнд, даатгалтай холбоотой төрийн болон хувийн байгууллагуудын 30 гаруй төрлийн үйлчилгээг үзүүлдэг бөгөөд улсын хэмжээнд 147 байршилд ажиллаж байна. Иргэн та ханшийн лавлагаа авахдаа Монголын хөрөнгийн биржийн 1 давхарт байрлах Гэрэгэ киоск болон бусад байршлуудад байгаа тус киоскноос төлбөрийн карт ашиглан үйлчлүүлэх боломжтой.



"ХОТ ДЕВЕЛОПМЕНТ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

"Хот Девелопмент" ХК нь 2021 оны 1-р сарын 04-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 01 тоот тогтоолоор компанийн өрийг хувьцаагаар солих, түүнтэй холбогдуулан хаалттай хүрээнд нэмж хувьцаа гаргахаар шийдвэрлэсэн.

Энэхүү үйл ажиллагаатай холбогдуулан 2021 оны 01 сарын 04-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцоогүй эсвэл хурлаас гарсан шийдвэртэй эсрэг саналтай байсан хувьцаа эзэмшигчдэд "Компанийн тухай хууль"-ийн 53 дугаар зүйлийн 53.1.1, 53.1.2-т заасны дагуу өөрийн эзэмшиж буй хувьцааг эргүүлэн худалдан авахыг компаниас эргүүлэн шаардах эрх үүсээд байна.

Иймд "Хот Девелопмент" ХК-ийн хувьцаа эзэмшигчид өөрийн хувьцаагаа эргүүлэн худалдах хүсэлтээ компани болон "БиДиСЕК ҮЦК" ХК-д хандан гаргана уу

Шаардах эрх хэрэгжүүлэх үнэ: 100 төгрөг

Хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг шаардах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдөр: 2021.01.04

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар шийдвэр гарсан огноо: 2021.01.04

Хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг шаардах эрх дуусах огноо: 2021.02.15

Холбоо барих утас : 75551919 (4), 99052845



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ТОП 20 ИНДЕКСИЙН БАГЦ ШИНЭЧЛЭГДЛЭЭ

Монголын хөрөнгийн биржийн “Үнэт цаасны үнийн индекс тооцох тухай журам” -ын дагуу ТОП-20 индексийн багцыг шинэчлэн 2021 оны 1-р сарын 26-ны өдрөөс мөрдөхөөр боллоо. 2020 оны үзүүлэлтээр ТОП-20 индексийн багцыг шинэчлэхэд өмнөх багцад багтаж байсан 17 компани хэвээр үлдэж, "МИК Холдинг", "Монгол Базальт", "Шарын гол" ХК-иуд хасагдаж шинээр "Бодь даатгал", "Махимпекс", "Дархан нэхий" ХК-иуд нэмэгдэн шинэчилсэн багцыг бүрдүүлж байна.

№	Үнэт цаасны нэр	Зах зээлийн үнэлгээ	Арилжигдсан үнийн дүн	Арилжаанд орсон өдөр /248 өдөр/	Өдрийн дундаж гүйлгээ
1	"АПУ" ХК	643,989,466,798	2,427,701,174	248	9,789,118
2	"Монгол шуудан" ХК	74,689,772,250	3,050,900,547	152	12,302,018
3	"Ард санхүүгийн нэгдэл" ХК	50,303,874,354	4,411,534,408	244	17,788,445
4	"Инвектор ББСБ" ХК	212,386,365,198	911,553,987	247	3,675,621
5	"Тавантолгой" ХК	371,816,312,000	629,957,389	241	2,540,151
6	"Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн"	229,845,710,094	662,167,207	202	2,670,029
7	"Говь" ХК	150,171,656,250	780,044,366	247	3,145,340
8	"Бодь даатгал" ХК	30,591,563,340	1,085,468,722	112	4,376,890
9	"Ард кредит ББСБ" ХК	22,988,000,000	2,190,301,292	241	8,831,860
10	"ЛэндМН ББСБ" ХК	25,152,000,000	1,599,723,505	247	6,450,498
11	"Мандал даатгал" ХК	29,966,476,800	1,060,867,440	246	4,277,691
12	"Ард даатгал" ХК	19,999,000,000	1,177,652,457	233	4,748,599
13	"Сүү" ХК	70,520,000,000	184,357,160	237	743,376
14	"Түмэн шувуут" ХК	33,796,000,000	392,882,470	240	1,584,204
15	"Улсын Их Дэлгүүр" ХК	45,273,655,500	319,600,057	188	1,288,710
16	"Монос хүнс" ХК	27,388,890,172	471,623,583	231	1,901,708
17	"Махимпекс" ХК	11,022,090,900	1,077,220,314	140	4,343,630
18	"Би Ди Сек" ХК	16,796,000,000	529,483,846	57	2,135,016
19	"Хөвсгөл алтан дуулга" ХК	10,069,573,316	606,579,345	125	2,445,884
20	"Дархан нэхий" ХК	16,449,527,520	159,415,341	123	642,804

“БУЛГАН УНДРАГА” ХК-ИЙН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААГ ТҮР ЗОГСООЛОО

Улсын Ерөнхий Прокурорын газрын Хяналтын прокурорын 2021 оны 01-р сарын 27-ны 3/01 тоот зөвшөөрөл, СЗХ-ны Улсын байцаагчийн 2021 оны 01-р сарын 27-ны өдрийн 03 тоот албан шаардлагын дагуу “Булган ундрага” ХК-ийн үнэт цаасны арилжааг 2021 оны 1-р сарын 28-ны өдрөөс эхлэн түр зогсоохоор боллоо.

ҮЙЛ ЯВДАЛ

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРЕЙШН ХАР МОРЬ ТАЛБАЙН ХАЙГУУЛЫН ҮР ДҮНГ ТАНИЛЦУУЛСАН БАЙНА

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн нь шинээр нээсэн Хар Морь талбайд 2020 оны 12 сард эцэслэсэн 2-р үе шатны өрөмдлөгийн хөтөлбөрөөр нэмэлт 3,085 метр, 14 цооног өрөмдсөнөөр нийт 4660 метр өрөмдлөгийн хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэн үр дүнг танилцуулсан байна.

Хар Морь талбайн баруун хэсэгт 4 км үргэлжлэх бүс нь газрын дөт гүнд өндөр агуулга бүхий алтны эрдэсжилт агуулж байгаа нь Баян Хөндий ордын ойролцоо томоохон алтны нээлтүүдийг хийх боломжтойг харуулсан байна.

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРЕЙШН НЬ ХАЙГУУЛЫН ХӨТӨЛБӨРИЙН ЭЦСИЙН ҮР ДҮНГ ТАНИЛЦУУЛАА

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (TSX:ERD | MSE:ERDN) (“Эрдэнэ Ресурс” эсвэл “Компани”) нь Хар Морь талбайд 2020 онд хийсэн хайгуулын өрөмдлөгийн эцсийн үр дүнгүүдийг танилцуулж, энэхүү шинэ талбайг үргэлжлүүлэн судлах хайгуулын хөтөлбөрийг эхлүүлснийг мэдээллээ.

Эрдэнэ Ресурсийн ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал Петер Акерли хэлэхдээ: 2020 оны эцсийн үр дүнгүүдэд тулгуурлан Хар Морь талбайг Баян Хөндий ордын нээлтээс хойш Хөндий Алтны Дүүрэг дэх хамгийн чухал нээлт хэмээн тодорхойлж байна. Өрөмдлөгийн интервалууд, дөрвөн километр трендийн турш тодорхойлогдож буй геофизикийн болон геохимийн тэмдэглэл нь Хар Морь талбайн хэтийн төлөвийг баталгаажууллаа. “Энэхүү нээлтийн талаар нарийвчлан судлаж, хайгуулын цогц хөтөлбөрийг боловсруулахаар экспертүүдийн багтай хамтран ажиллахаар болоод байна. Бид 2021 оны 1-р улиралд хайгуулын хөтөлбөрүүдийг эрчимтэй хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд хөтөлбөр эцэслэгдмэгц дэлгэрэнгүй танилцуулна” хэмээн хэлжээ.

Энэхүү шинэ нээлт нь Хар Морь талбайн хязгаарлагдмал судалгаа хийгдсэн хэсэгт оршиж байгаа бөгөөд 30.6 г/т алтны агуулга бүхий 1 метрийн интервал огтолсон AAD-48 цооногос баруун зүгт 1 км-т байрладаг юм. Энэхүү AAD-61 цооног нь урьд нь танилцуулсан, хоорондоо 500 метр зайтай орших AAD-51 ба AAD-57 цооногуудын дунд буюу AAD-57 цооногос өмнө зүгт 180 метрт оршдог. AAD-61 цооногт 14 метрээс эхлэн 1.1 г/т алтны агуулга бүхий 26 метр багтаасан 0.53 г/т алтны агуулга бүхий 130 метрийн интервал огтолсон нь Хар Морь талбайн хамгийн зузаан алтны эрдэсжилт бүхий бүс юм.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ



Монгол Улс, Улаанбаатар
хот 15160

Сүхбаатарын талбай-3



+976 11-313747-2129



+976 11-325170



Info@mse.mn



WWW.MSE.MN